

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 05-р сарын 10 өдөр

Дугаар №01/21

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2021 оны 5-р сарын 10-ны өдрийн 15.00 цагт эхлүүлсэн.

ХЭХурлын дарга: Б.Цолмон /Кашмер Холдинг ХХК-н Арилжааны хэлтсийн дарга/

Тооллогын комиссын дарга: Э.Тогосмаа /Ариг гал ХК-н ня-бо/

Тооллогын комиссын гишүүн: Д.Даваасүрэн /Монноос ХК-н Ерөнхий менежер/

С.Бадарч /Монноос ХК-н нярав/ нар ажилласан.

Хуралд оролцсон: Монноос ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

1. Д.Гиваапил- 69732ш
2. Адам Холдворсын итгэмжлэлээр Х.Эрдэнэбаяр-69824ш
3. С.Алимаа-14443ш
4. Марал импекс ХХК-ийн итгэмжлэлээр Д.Мөнхбат-69824ш
5. Шандас импекс ХХК-ийн итгэмжлэлээр М.Гөлгөө-20526ш

Монноос ХК-ийн нийтэд гаргасан 350877ш хувьцаанаас 244349ш хувьцаа эзэмшигч буюу 69,6%-ийн саналын эрх бүхий оролцогч оролцсноор хурлыг хүчинтэй гэж үзээд хурлыг 15 цаг 00 минутад эхлүүлж, 1 цаг 30 минутад багтаан явуулахаар тогтоов.

Хурлын дэгийг ХЭХурлын дарга Б.Цолмон танилцуулж, хуралд оролцогчдын 100%-ийн саналаар батлав.

Хурлаар хэлэлцсэн асуудлууд:

1. Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан
2. Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлт
3. ТУЗ-ийн хараат болон энгийн гишүүдийг сонгох
4. Компанийн удирдлагын зардлыг хэлэлцүүлэх
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл
6. Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулах, саналын дүнг гаргах, ХЭХ-д саналын дүнг танилцуулах

Хурлаар хэлэлцсэн нь:

1. **Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааг Х.Эрдэнэбаяр танилцуулав.**
 - 2021 оны 4 сарын 20-ноос Монноос ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Д.Мөнхбатыг томилж байгаа. 2020 оны үйл ажиллагааны тайланг Х.Эрдэнэбаяр танилцуулах болно.
 - 2020 онд түрээсийн үйл ажиллагаа явуулж ажилласан. Агуулахууд-5, гаднах талбайн түрээслэж ажилласан. 2020 онд нийт 82,1сая.₮-ийн орлого олж, 76,7сая.₮-ийн зардал гаргаж, 5,4сая.₮-ийн ашигтай. Өмнөх оноос 35,6сая.₮ буюу 30%-аар орлого буурсан.
 - Өвлийн бэлтгэл ажлын хүрээнд гаднах инженерийн шугам сүлжээнд хэсэгчилсэн засвар үйлчилгээ хийсэн.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- Гаднах 20м уурын шугмыг шинэчлэн засварлах ажил ноос угаах үйлдвэрлэл явуулах боломжгүй болсноос хийгдээгүй..
 - Монноос ХК-ийн 8 давхар оффисын барилгын чанар байдлын дүгнэлтийг гаргуулж, санхүүжилтээс шалтгаалж, шаардлагатай засварын ажил хийгдээгүй.
 - Оффис, харуулын байр, КНС-ын цахилгаан хангалтыг Орхон дээд сургуулиар дамжуулан Ариг гал ХК-ийн тэжээлийн шугамаас авах ажлыг гүйцэтгэсэн.
- 2. Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-ийн аудитын хорооноос өгсөн дүгнэлтийг** нарийн бичиг М.Тунгалаг танилцуулав.
ТУЗ-ийн аудитын дэд хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Бүрэнтэгшийн дүгнэлтэнд:
- Хөл хориотой холбоотойгоор түрээслэгч компаниуд түрээслэхээ зогсоосон нь муу үзүүлэлт ба өөр түрээслэх компаниудыг олох ажил хангалттай хийгдээгүй байна.
 - Оффис, харуулын байр, КНС-ын цахилгаан хангалтыг Ариг гал ХК-ийн тэжээлийн шугамаас авах болсон нь ололттой байна.
 - Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа болох ноос угаах шугамаа сэргээн засварласан ч захиалгагүйгээс үйлдвэрлэл явуулаагүй.
 - Ашиглахгүй байгаа мал эмнэлгийн байр, зоорь, 8 давхар оффисын барилга, бусад эзэмшил газруудын ашиглалтыг сайжруулах, түрээслэх, үйл ажиллагаа явуулах зэргээр эдийн засгийн эргэлтэнд оруулахыг Компанийн гүйцэтгэх удирдлагад шаардаж байна.
- Энэхүү аудитын дүгнэлтээс Монноос ХК ГЗахирал Мөнхбатыг 2021 оны үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнд хүргэж ажиллахыг шаардаж байна.
- 3. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийг сонгох**
ТУЗ-ийн энгийн гишүүд: С.Мөнхжаргал- Кашмер Холдинг ХХК ГЗ
Адам Холдсворт- NPEAL ХХК ГЗ
С.Алимаа- Дизайн концепт ХХК ГЗ
Х.Эрдэнэбаяр- Монноос ХК ГЗ
Ц.Цэнгэлбаяр- Ариг гал ХК Ерөнхий ня-бо
П.Оюунбаяр- Монмьндас ХХК Ерөнхий менежер
ТУЗ-ийн хараат бус гишүүд: Л.Бүрэнтэгш-БЦД ХХК ГЗ
И.Сэр-Од- Монголын бизнесийн зөвлөлийн дэд захирал
Х.Оюунгэрэл- Бадрах өгөөж ХХК ГЗ нарыг ХЭХуралд оролцогчдын 100%-ийн саналаар томилов.
- 4. Компанийн удирдлагын зардлыг** ТУЗ-ийн нарийн бичиг М.Тунгалаг танилцуулав.
Монноос ХК-ийн 2020 оны санхүүгийн балансаар 82,1сая.₮-ний орлого олж, 76,7сая.₮-ийн зардал гаргаж, татварын өмнөх ашиг 5,4сая.₮ гарсан байна.
Монноос ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалинг жилд 1,680,000₮-өөр төлөвлөхийг батлав.
- 5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой санал, шүүмжлэл**

Мөнхбат –2020 онд Түрээсийн орлого буурсан байна. Орлогыг нэмэгдүүлэхийн тулд ямар арга хэмжээ авсан бэ?

Эрдэнэбаяр – Ковидын хөл хорионоос шалтгаалж, борлуулалтын орлого буурсан шалтгаанаар 8 түрээслэгч компаниуд талбай түрээслэх ажиллагаагаа зогсоосон. Талбай түрээслэх олон удаа зар тавьсан боловч түрээслэх компаниуд нэмэгдээгүй.

“МОННООС”
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

С.Алимаа – Монноос компанийн энэ том талбайнуудыг түрээслэж, орлогоо нэмэгдүүлж болмоор л юм. 2021 онд борлуулалтын орлогоо нэмэгдүүлэх ямар арга хэмжээ талаар шинээр томилогдсон захирал төлөвлөгөө боловсруулж ажиллах шаардлагатай.

Мөнхбат- 2021 онд Борлуулалтын орлого нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөгөө хэрэгжүүлж ажиллана.

6. **Хурлаар хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, саналын дүнг гаргаж** Тооллогын комиссын дарга Э.Тогосмаа танилцуулав.

ХЭХурлаас гарсан шийдвэр:

1. Монноос ХК-ийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагааны тайлан, ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг 100%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн энгийн гишүүнээр кумулятив саналаар Адам Холдсворт, С.Мөнхжаргал, С.Алимаа, Х.Эрдэнэбаяр, Ц.Цэнгэлбаяр, П.Оюунбаяр нарыг тус тус сонгосныг батлав.
3. ТУЗ-ийн хараат гишүүнээр кумулятив саналаар Л.Бүрэнтэгш, И.Сэр-Од, Х.Оюунгэрэл нарыг тус тус сонгосныг батлав.
4. Компанийн 2021 оны удирдлагын зардлыг батлав.

Тэмдэглэл бичсэн: Хурлын нарийн бичгийн дарга

Зөвшөөрсөн: Хурлын дарга



М.Тунгалаг

Б. Цолмон